

ТЭМДЭГЛЭЛТ ОЙ, МЭДЭЭЛЭЛ

БУРИАД ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ

Буриадын Шинжлэх ухааны нэг уламжлалт салбар нь Шинжлэх ухааны монгол судлал юм. Буриадын Дорж Банзаров, Галсан Гомбаев, Гомбожав Цыбиков, Михайл Хангалов, Ринчин Номтаев гэх мэт томоохон дорнодахин судлаачдын нэр бүр хувьсгалаас өмнө ч тодорч байв. Тэдний бүтээл өндөр үнэлэгддэг билээ. Зохиол бүтээлээрээ тэд дорнодахины судлалыг хөгжүүлэх хэрэгт багагүй хувь нэмэр оруулсан юм.

Монгол судлал нь Зөвлөлт засгийн жилүүдэд шинжлэх ухааны чиглэлийн хувьд мэдэгдэхүйц алхам хийсэн билээ. Буриадын эрдэмтэд 20-30-аад оны үед сонирхолтой бүтээл нэлээдийг туурвижээ. Профессор Г.Цыбиков монгол хэлзүйн зарим сурах бичиг, Монгол хэлний сурах бичгүүд тууривав. Буриадын шинжлэх ухааны хороо (Буручком)-ны эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллаж байхдаа Г.Цыбиков 1927 онд Улаанбаатарт иржээ. Энэ айлчлалтын үр дүн нь “1927 онд Улаанбаатарт айлчилсан өдрийн тэмдэглэл” болно. БНМАУ-д нэг бус удаа ирж байсан Буриадын Шинжлэх ухааны хорооны дарга Б.Барадин бол “Монголын хэлний соёлын ангиллын асуудлууд”, “Лаврангийн алтан ганжирт сүмийн Майдар бурхан” болон бас бусад бүтээлүүдийн зохиогч юм.

Ленинградын Дорнодахины амьд хэлний институт, Ленинградын их сургуулийг төгсөөд 30-аад оны эхээр болон дундуур ЗСБНАБУ-д ирсэн сэхээтнүүд монгол судлалын хөгжилтөд дорвитой хувь нэмэр оруулсан юм. Энэ бол К.Черемисов, Д.Амоголонов, Т.Бертагаев, Д.Алексеев, Г.Румянцев нар билээ. Монгол ба Буриадын хэл шинжлэл, Монголын сурвалж бичиг судлалын асуудлаар тэд зохиол бүтээл туурвисан юм. Б.Цыбиковын “Унгернчуудыг бут ниргэсэн нь” гэдэг нэгэн сэдэвт зохиол 1947 онд хэвлэн нийтлэгдэв. Зохиогч энэ бүтээлээ монголын хувьсгалын удирдагч Д.Сүхбаатарын тухай баримтат материал, Монголын хувьсгалчид болон бусад зохиолчдын бүтээл зэрэг монгол сурвалж бичгүүдийг ашиглан бичсэн юм. Е.Залкинд XIX-XX зууны үеийн монгол-буриадын харилцаагаар, К.Герасимова ламын шашны талаар хэд хэдэн бүтээл туурвижээ.

60-аад оны эхээр Буриадын Шинжлэх ухааны академик төв байгуулагдсантай холбогдож Дорнодахины судлал, түүний дотор шинжлэх ухааны монгол судлалыг хөгжүүлэн өргөн хэтийн төлөв нээгдсэн юм. Хилийн чанадах Дорнодын хэлтэс байгуулагдсанаас хойш удалгүй Монгол судлалын сектор байгуулагдлаа. Буриадын эрдэмтэд монгол, төвд сурвалж бичгүүд гар бичмэл, модон барын судрууд, монгол ба төв Азийн бусад ард түмний түүх, соёлын цаг үеийн асуудлын судалгаа шинжилгээг өргөн хэмжээтэйгээр өрнүүлж байна.

Энэхүү тоймд Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Автономит Буриад Улсын монгол судлаачдын сүүлийн 10 жилийн бүтээлүүдээс зөвхөн гол томоохон бөгөөд дорвитойгоос нь дурдаж болох юм.

Түүхийн шинжлэх ухааны дэд эрдэмтэн П.Балданжапов бол сурвалж зохиол судлалын мэргэжилтэн юм. Тэрээр XVIII зууны он тооллын бичиг “Алтан товч”-ийг монголоос орос руу орчуулж, “XVIII ба XIX зууны Монголын хэл зүйн зохиолууд” гэдэг бүтээл туурвилаа. Тэр мөн “цагаан түүх”-ийг хэвлэлд бэлтгэв. Хэл шинжлэлийн ухааны дэд эрдэмтэн Ц.Дугарнимаев “Билгийн толь”-ийн орчуулга, тайлбар хийсэн юм. Монгол Гэсэрийн судалгааг ахмад монгол судлаачийн нэг М.Хомонов хийж байна. “Монголчуудын гэрлэлт, гэр бүл” гэдэг угсаатны зүйн бүтээлийг Г.Банчиков тууривав. Түүхийн шинжлэх ухааны дэд эрдэмтэн Г.Заятуев “Хувьсгалт Монголын анхны сонинууд”, “Р.Балдаев “БНМАУ дахь ардын боловсрол” гэдэг номуудыг хэвлүүлэв. Буриадын томоохон монголч эрдэмтний нэг, түүхийн шинжлэх ухааны доктор Д.Улымжиев “БНМАУ дахь хөдөө аж ахуйн социалист өөрчлөн байгуулалт” гэдэг нэгэн сэдэвт зохиол нийтлүүлэв.

Хэл шинжлэлийн ухааны доктор Ц.Цыдендамбаев “Буриадын түүхийн мэдээ, угийн бичиг” гэдэг нэгэн сэдэвт зохиолдоо монголын ард түмний гарал судлал, монгол-буриадын хэлний холбоог авч үзлээ. Хэл шинжлэлийн шинжлэх ухааны доктор В.Рассадин “Сибирийн Түрэг хэлнүүд дэх монгол-буриад зээлдлэг” гэдэг ном хэвлүүлэв. “Профессор Г.Цыбиковын түүвэр зохиол” хоёр ботиор хэвлэгдэн гарлаа. Ц.Ванчикова, Р.Дугаров, В.Цыремпилов нарын зэрэг залуу эрдэмтэд монголчуудын түүх, соёлын талаар зохиол бүтээлээ тууривилаа.

Монгол судлалын сектор сүүлийн жилүүдэд БНМАУ дахь соёлын байгуулалтын асуудал, Зөвлөлт-Монголын соёл, шинжлэх ухааны харилцаагаар судалгаа явууллаа. 1983 онд “ЗСБНХУ, БНМАУ-ын шинжлэх ухаан, соёлын хамтын ажиллагаа” гэдэг нэгэн сэдэвт зохиол хэвлэгдсэн бөгөөд уг бүтээлийн зарим бүлгийг бэлтгэхэд ЗХУ-ын бусад бүгд найрамдах улс, хотуудын эрдэмтэд оролцлоо. Түүнээс өмнө “ЗСБНХУ, БНМАУ-ын соёл, шинжлэх ухааны харилцаа” гэдэг эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэлийг Москвад хэвлэн гаргалаа. Түүнд буриад болон Монголын түүхчдийн өгүүлэл нийтлэгджээ.

Ш.Чимиддоржиев
“Новости Монголии” сонины 1985 оны
8-р сарын 20-ны дугаараас Э.Пунцаг
хэсэгчлэн орчуулав.